Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 тоот тушаалын
7 дугаар хавсралт

Санхүү, хөрөнгө оруулалтын газар

2024 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| № | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэл-ийн хувь | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | | Өөрийн үнэлгээ | ХШҮ |
| Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ | | | | | | | | | |
| 1.1. | Урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан боловсрол, шинжлэх ухааны салбарт хамаарах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах | - | - | - | - | | Монгол Улсын урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан боловсрол, шинжлэх ухааны салбарт хамаарах арга хэмжээг хэрэгжүүлэхээр 2024 оны төсвийн тухай хуулинд нийт 4.2 их наяд төгрөгийн төсөв батлуулан, хэрэгжилтийг хангаң ажиллаж байна. Бодлогын | 100% | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | баримт бичигт туссан зорилго, зорилтыг Боловсрол, шинжлэх ухааны сайдын багцаас хэрэгжүүлэхээр хөтөлбөр, арга хэмжээний тушаал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр БШУСайдын 2024 оны "Худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөө батлах тухай" А/27 дугаар тушаалыг тус тус батлуулан, хэрэгжилтийг хангаж байна. | | |
| 1.1.1 | Ерөнхий боловсролын сургуулийн 3 ээлжийг 1 ээлжид шилжүүлэх, 1 ээлжтэй сургуулийн сургалтын төлөвлөгөөг шинэчлэн туршина. | - | Арга хэмжээний төлөвлөгөө | - | Судалгаа хийж, төлөвлөгөө боловсруулан батлуулсан байна | - | 2023-2024 оны хичээлийн жилд улсын хэмжээнд 68 сургуулийн 33 мянган сурагч 3 ээлжээр хичээллэх эрсдэлд учирсан байна. Үүнд нийслэлд 47 сургууль, орон нутгийн 21 | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сургууль байна. Сургууль тус бүрд суудлын хүчин чадлаас хэтэрсэн хүүхдийн тоо харилцан адилгүй ба хамгийн бага нь 114 хүүхдийг 3 дахь ээлжрүү шилжүүлж байхад хамгийн 2352 хүүхэд 3 дахь ээлжээр хичээллэж байна. Тус эрсдлийг шийдвэрлэхийн тулд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй барилгын ажлын явцыг сайжруулж, зарим төсөл арга хэмжээний магадлалыг цаг алдалгүй хийх, барилгыг хэсэгчилсэн байдлаар ашиглалтад оруулах, гүйцэтгэл өндөртэй төсөл арга хэмжээний санхүүжилтыг | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | шийдвэрлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажилласан. | | |
| 1.1.2 | Ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллеж, их сургуулийн хотхоны дахин төлөвлөлт хийгдэж, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө боловсруулж батлуулна. | - | Төлөвлөгөөний хэрэгжилт | - | 1. Судалгаа хийж төлөвлөгөө батлуулсан байна. 2. Төлөвлөлт хийгдэж, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө боловсруулсан байна. | - | "АЛСЫН ХАРАА-2050" МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫн баримт бичигт Зарим их, дээд сургуулиудыг мэргэжлийн чиглэл, салбараар нь төрөлжүүлж, дагуул хотуудад хотхон байгуулан шилжүүлэхээр заасан тус арга хэмжээний хүрээнд Төрийн өмчийн зарим боловсролын сургалтын байгууллагын талаар авах арга хэмжээний тухай Засгийн газрын 293 тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор өмнө үүссэн хуримтлагдсан өр, авлагыг | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | барагдуулах, хөрөнгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх, сайжруулах чиглэлээр авах арга хэмжээний санал боловсруулж, танилцуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн дүгнэлт, тайланг үндэслэн нийт 1.9 тэрбум төгрөгийг төсвийн төсөлд тусган тооцов. | | |
| 1.1.3 | Суралцагчийн ялгаатай хэрэгцээг хангах сургалтын орчин, тохирох хэрэглэгдэхүүний г үе шаттай нэмэгдүүлэх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллана. | Батлагдсан төсөв, төсөл, хөтөлбөрий н санхүүжилт | Санхүүжилтий н эх үүсвэрийг шийдвэрлэж, тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгсөн байна. | - | Худалдан авах ажиллагааг холбогдох хуулийн дагуу зохион байгуулсан байна. | Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж, цэцэрлэг, сургуульд холбогдох хэрэглэгдэхүүни йг нийлүүлж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсрол эзэмших хүртээмжийг нэмэгдүүлсэн байна. | Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй 0-18 хүртэлх насны хүүхдэд боловсрол, хүүхэд хөгжил, эрүүл мэндийн цогц үйлчилгээ хүргэх хөтөлбөрийг насан туршийн боловсролын төв эсхүл, мэргэжлийн төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | болох бөгөөд холбогдох зардлыг төсвөөс санхүүжүүлэх БЕХ-н 10.1.9-д “Хөгжлийн бэрхшээлтэй суралцагч нь бусад суралцагчийн адил боловсрол эзэмших тэгш боломж, нөхцөлөөр хангагдах” гэж заасны хүрээнд ерөнхий боловсролын 480 сургуульд хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын тохируулгат орчин нөхцөл бүрдүүлэх, 105 хүүхэд хөгжлийн танхим байгуулах бөгөөд нэг төв нь дунджаар 203.0 сая төгрөг, нийт 32.2 тэрбум төгрөг шаардагдахаар байна. | | |
| 1.2. | Боловсрол, шинжлэх ухааны хууль | - | - | - | - | | Боловсролын ерөнхий хууль болон түүнийг | 100% | 100 % |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | тогтоомжид заасан эрх зүйн актыг боловсруулж, батлуулах, хэрэгжилтэд мэргэжил арга зүйгээр хангах, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах | | | | | дагалдан гарсан хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэх эрх зүйн актуудыг боловсруулж, батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тухайлбал, хувьсах зардлын дийлэнхи хэсгийг бүрдүүлж буй бүрэлдэхүүн нь дундаж цалин хөлсний зардал бөгөөд Засгийн газрын 2022 оны 107 тоот тогтоолоор шийдвэрлэж салбарын багш, зарим ажилтнуудын үндсэн цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоож, нийтлэг авдаг нэмэгдлийг цалин хөлсний бүрэлдэхүүнд тусган өөрчилж, цаашид зөвхөн сурлагын чанар, | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ахицын буюу гүйцэтгэлийн үнэлгээнд үндэслэн багш, сургалтын байгууллагад урамшууллын санхүүжилтийг олгохоор шийдвэрлэж, хэрэгжилтийг зохион байгуулсан. 2021-2022 оны хичээлийн жилд төрийн өмчийн сургууль, цэцэрлэгийн нийт 51673 багш, туслах багш нарын 23 хувь нь 0-5 хүртэлх жилдээ ажиллаж буй залуу багш нар, тэдгээрийн үндсэн цалин сард 749.7 мянган төгрөг байсныг үр дүнд 1,005.1 мянган төгрөгийн үндсэн цалинг сар бүр авч, уг суурь цалингаас бусад нэмэгдлүүдээ тооцуулах, дээр нь гүйцэтгэлийн | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | үнэлгээний үр дүнгээс хамаарч урамшуулалт цалинг сар тутамд 10-25 хүртэл хувиар авч болох боломжтой бодитоор бүрдсэн байна. | | |
| 1.2.1 | Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуульд заасан журам, дүрэм, стандартыг боловсруулж, батлуулна. | Үйл ажиллагааны зардлаар | Хуульд заасан журам, дүрэм, стандартын тоо | - | Хуульд заасан журам, дүрэм, стандартыг боловсруулж, батлуулсан байна. | Батлагдсан журам, дүрэм, стандартын хэрэгжилтийг хангахад мэргэжил арга зүйгээр хангах, олон нийтэд сурталчлан таниулсан байна. | Боловсролын салбарын 2022 оноос хойш хэрэгжиж буй төсвийн шинэчлэлийн хүрээнд мэргэжлийн болон техникийн боловсролын салбарт санхүүжилтийн тогтолцоогоор нь дамжуулж төсвийн нэг төгрөг бүрийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор хагас бие даасан, мэргэжлийн өөрийн өртгийг үндэслэн тогтоосон нэг сурагчид ногдох хувьсах зардал, үр дүн, чанар, гүйцэтгэлд | 100% | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | суурилсан санхүүжилт, төсвийн шинэчлэлийг Мэргэжлийн болон техникийн боловсролын салбарын 2023 оны батлагдсан төсөвт багтаан хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх, багш ажилчдын нийгмийн баталгааг хангах боломжийг бүрдүүлэх, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх өөрчлөлтүүдийг тусгасан эрх зүйн орчныг бий болгоод байна. | | |
| Гурав. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ | | | | | | | | | |
| 3.6. | Сургуулийн өмнөх, ерөнхий болон тэгш хамран сургах | - | - | - | - | | Бүх хүүхдийг тэгш хамран сургах ажлын хүрээнд хүнд | 100% | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | боловсролын хөгжлийн чиглэлээр батлагдсан бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрийн удирдлага, зохицуулалтыг хангах чиглэлээр дүрэм, журам, удирдамж, аргачлал, зөвлөмж боловсруулах, төслийн хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангах, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, эрх зүйн баримт бичгийн төсөл боловсруулах, батлуулах | | | | | хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй 0-18 хүртэлх насны хүүхдэд боловсрол, хүүхэд хөгжил, эрүүл мэндийн цогц үйлчилгээ хүргэх хөтөлбөрийг насан туршийн боловсролын төв эсхүл, мэргэжлийн төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж болох бөгөөд холбогдох зардлыг төсвөөс санхүүжүүлэх хүрээнд 2024 онд 160 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлсэн байна. Мөн Монгол Улсын малчин өрх болон алслагдсан бүс нутагт амьдарч буй өрхийн хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хамруулах орчин нөхцөлийг бүрдүүлснээр хүүхдийн хөгжлийн ялгаатай байдал буурна. 2023 оны байдлаар малчин өрхийн 3-5 насны 47,413 мянган хүүхэд байгаагийн 33,544 /70,7 хувь/ нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байгаа бөгөөд цаашид нэмэгдүүлэх, сургалтын чанарыг сайжруулах, 5 настай малчдын хүүхэд бүрийг системтэй сургалтад хамруулан сургуульд бэлтгэх зайлшгүй шаардлагатай байна. БШУ-ны сайдын 2022 оны А/ 224 дүгээр тушаалаар "Сургуулийн | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өмнөх боловсролын хувилбарт сугалт зохион байгуулах журам"-ыг баталсан. Журам батлагдсанаар алслагдсан бүс нутагт оршин амьдарч буй /хилийн застав болон малчдын / өрхийн 3-5 насны хүүхдэд боловсрол эзэмшүүлэх хувилбарт сургалтын орон тооны багшийг хөдөөгийн сумын цэцэрлэг бүрт ажиллуулж 2023 онд 87 байгаа бөгөөд цаашид үе шаттай нэмэгдүүлнэ. 2024 онд хувилбарт сургалтын 150 багшийг чадвахжуулах, малчин болон хилийн заставд амьдарч буй өрхийн 5 настай 6000 мянган | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хүүхдэд ном,сургалтын хэрэглдэгхүүнээр хангахад 197.2 сая төгрөг зарцуулагдана. | | |
| 3.6.1 | Хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсрол эзэмшихэд дэмжлэг үзүүлэх дэмжих төвийн бүтэц орон тоо, үйл ажиллагааны дүрмийн төсөл боловсруулж, батлуулна. | - | Засгийн газрын гишүүдийн хамтарсан тушаал | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд цогц дэмжлэг үзүүлэх аргачлал | Дүрмийн төслийг боловсруулж, хэлэлцүүлнэ. | Дүрмийн төслийг батлуулсан байна. | Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй 0-18 хүртэлх насны хүүхдэд боловсрол, хүүхэд хөгжил, эрүүл мэндийн цогц үйлчилгээ хүргэх хөтөлбөрийг насан туршийн боловсролын төв эсхүл, мэргэжлийн төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж болох бөгөөд холбогдох зардлыг төсвөөс санхүүжүүлэх хүрээнд 2024 онд 160 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлсэн байна. | 100% | 90% |
| 3.7. | Чанарын болон гүйцэтгэлийн | - | - | - | - | | "Боловсролын сургалтын | 100% | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | үнэлгээ, олон улсын үнэлгээг зохион байгуулах ажлыг удирдлага, зохицуулалтаар хангах | | | | | | байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам"-ыг Засгийн газрын 25 дугаар тогтоолоор шинэчлэн баталж, нэг сарын урамшууллын дээд хэмжээг 40 хувь байхаар тогтоож 2024 онд 18 мянган багшид 61.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг улсын төсвөөс олгохоор тооцоолсон. | | |
| 3.7.1 | Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургалтын байгууллагын болон багшийн ажлыг үнэлэх, | Үйл ажиллагааны зардлаар | Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургалтын байгууллага болон багшийн үнэлгээний үр | Цэцэрлэг /байгууллага/ - 90.2 Цэцэрлэг /багш/ - 90.11 Сургууль | - | Цэцэрлэг /байгууллага/ - 92 Цэцэрлэг /багш/ - 92 Сургууль /байгууллага/ - 76,5 Сургууль | "Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын | 100% | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | дүгнэх ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангаж, бодлогын зөвлөмж боловсруулна. | | дүн | /байгууллага/ - 74.22 Сургууль /багш/ - 75.71 | | /багш/ - 77,5 | гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам"-ыг Засгийн газрын 25 дугаар тогтоолоор шинэчлэн баталж, нэг сарын урамшууллын дээд хэмжээг 40 хувь байхаар тогтоож 2024 онд 18 мянган багшид 61.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг улсын төсвөөс олгохоор тооцоолж байна. | | |
| 3.8. | Боловсрол, шинжлэх ухааны салбарын төсөв, санхүү, эдийн засгийн төлөвлөлтийг сайжруулах | - | - | - | - | | Манай улсын хувьд ковид-19 цар тахлын үед Боловсрол, шинжлэх ухааны салбарт хуваарилж, зарцуулж буй төсөв 2021 оны гүйцэтгэлээр ДНБ-ий 3.9 хувь, төсвийн нийт | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | зарлагын 10.8 хувь хүртэл буурсан бол 2022-2023 онд ДНБ-ий 4.4-4.9%, улсын төсвийн нийт зарлагын 12.8-13.2% хүртэлх хэмжээнд нэмэгдэхээр төлөвлөгдөж, улмаар энэ үзүүлэлт 2023 оны төсийн тодотголоор ДНБ-ий эзлэх хувь 4.5 %, нэгдсэн төсвийн нийт зарлагын 13.8%-д хүрсэн. БШУ-ны төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн нийт зарлага нь ДНБ-ий 5%, төсвийн нийт зарлагын 12%-тай дүйцэхүйц хэмжээнд батлагдав. | | |
| 3.8.1 | Боловсрол, шинжлэх ухааны төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын | 3,483.3 тэрбум төгрөг | Хуваарь болон баримтлах чиглэл | 2,576.5 тэрбум төгрөг | Хуваарь болон баримтлах чиглэлийг боловсруулж, баталгаажуулан хүргүүлж, | - | Сар болгоны төсвийн хуваарийг батлуулж, төсвийн хүрээнд баримтлах | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | байгууллагуудад 2024 оны батлагдсан төсвийн санхүүжилтийн сар улирлын хуваарь болон төсөвт баримтлах чиглэлийг боловсруулан хүргүүлнэ. | | | | хэрэгжилтийг хангахад удирдлага, мэргэжлийн арга зүйгээр хանган, хяналт тавьж бүрэн хэрэгжүүлсэн байна | | чиглэлийг гаргаж, харьяа байгууллагуудад цуврал сургалтуудыг зохион байгуулсан. | | |
| 3.8.2 | Боловсрол, шинжлэх ухааны салбарын 2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд дүн шинжилгээ хийж, дүгнэлт боловсруулан цаашид анхаарах асуудал, зарчмын талаар харьяа байгууллагын төсвийн мэргэжилтнүүдтэй хамтарсан цахим хэлэлцүүлгийг зохион байгуулна. | 2,689.2 тэрбум төгрөг | Үйл ажиллагааны хэрэгжилт | 2,331.7 тэрбум төгрөг | Тухайн жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланд дүн шинжилгээ хийсэн байна. | Хэлэлцүүлэг зохион байгуулсан байна. | Боловсрол, шинжлэх ухааны салбарын багцын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргахтай холбогдуулан 2024 оны 02, 03 дугаар сард 21 аймаг 9 дүүргийн Боловсрол шинжлэх ухааны газар, хэлтсийн дарга, нягтлан бодогч нарыг оролцуулсан цахим сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Холбогдох | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хууль, дүрэм, журмын дагуу салбарын нэгтгэсэн тайланг гаргаж Төвсийн хуульд заасан хугацаанд Үндэсний аудитын газар, Сангийн яаманд нэгтгүүлэх ажлыг хийж гүйцтгэсэн. | | |
| 3.8.3 | Боловсрол, шинжлэх ухааны төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайланг гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлнэ. | - | Сангийн яам, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Үндэсний аудитын газарт санхүүгийн нэгдсэн тайланг хүргүүлсэн байна. | Хуулийн хугацаанд хүргүүлсэн байна. | Зөрчилгүй дүгнэлт гаргуулах нөхцөлийг бүрдүүлж, тайлагнасан байна. | - | Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээний 2023 оны санхүүгийн нэгдсэн тайланд нийт 1812 байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэж Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5 дахь хэсэгт заасан хугацааны дагуу Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 1а/1341 тоот албан | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | бичгээр Үндэсний аудитын газарт, мөн Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 1а/1685 тоот албан бичгээр Сангийн яаманд тус тус хүргүүлсэн. | | |
| 3.8.4 | Боловсрол, шинжлэх ухааны төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайланд аудитын байгууллагын дүгнэлт гаргуулсан байна. | - | Аудитын байгууллагын дүгнэлт гаргуулсан байна. | Зөрчилгүй дүгнэлт | Аудитын байгууллагаас шаардсан материалыг цаг тухай бүр гаргаж өгч ажиллана | - | Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээний 2023 оны санхүүгийн нэгдсэн тайланд нийт 1812 байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэж Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5 дахь хэсэгт заасан хугацааны дагуу Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 1а/1341 тоот албан бичгээр | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Үндэсний аудитын газарт, мөн Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 1а/1685 тоот албан бичгээр Сангийн яаманд тус тус хүргүүлсэн. | | |
| 3.8.5 | Боловсрол шинжлэх ухааны төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн нэгдсэн тайланг гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлнэ. | - | Сангийн яаманд хуулийн хугацаанд хүргүүлсэн байна. | Сангийн яаманд хуулийн хугацаанд хүргүүлсэн. | Боловсрол, шинжлэх ухааны салбарын байгууллагын хагас жилийн санхүүгийн тайлан гаргахтай холбоотой мэдээлэл, арга зүйгээр ханган ажилласан байна. | Санхүүгийн нэгдсэн тайланг хуулийн хугацаандаа баталгаажуулж, хүргүүлсэн байна. | Тайлан гаргах бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна. Хагас жилийн тайланг хуулийн хугацааны дагуу гаргаж, холбогдох байгууллагуудад хүргүүлнэ. | 100% | 100 % |
| 3.8.6 | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага, төсвийн захирагч нарыг мэдээлэл, арга зүйгээр | - | Төсвийн ерөнхийлөн захирагчийн мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн, үнэн зөв оруулж, мэдээлсэн байна. | - | Тайлант хугацаанд хамаарах төсвийн ерөнхий захирагчийн болон харьяа байгууллагуудын мэдээллийг бүрэн оруулж, тайлагнасан | Улирал бүр дүн шинжилгээ хийж, мэдээлэл арга зүй, удирдлагаар хангасан байна | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төсвийн ерөнхийлөн захирагчийн Хөтөлбөр арга хэмжээний мэдээллийг цахим системд цаг тухай бүрд | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хангах, хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж тайлагнана | | | | байна. | | нь оруулах болон холбогдох байгууллагуудад мэдээлэл өгч ажилласан | | |
| 3.8.7 | Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт үндэслэн боловсрол, шинжлэх ухааны салбарын дунд болон урт хугацааны хөрөнгө оруулалтын бодлого, зардлын хүрээ, төлөвлөлтийг тодорхойлно. | Үйл ажиллагаан ы зардлаар | Салбарын дунд болон урт хугацааны хөрөнгө оруулалтын бодлого тодорхойлогдс он байх, судалгаа, тооцоолол хийх төсөл, арга хэмжээний тоо | 275 төсөл, арга хэмжээний судалгаа хийгдсэн. | Газар зүйн мэдээллийн системд тулгуурлан шаардлагатай төсөл, арга хэмжээний хэрэгцээ, шаардлагыг тодорхойлсон байна. | Газар зүйн мэдээллийн системд тулгуурлан шаардлагатай төсөл, арга хэмжээний хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, 275-аас доошгүй төсөл, арга хэмжээний тооцоо, судалгаа, шинжилгээ хийгдсэн байна. | Салбарын дунд болон урт хугацааны хөрөнгө оруулалтын бодлогыг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалттай уялдуулан боловсролын сургалтын байгууллагын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, газар зүйн мэдээллийн системийн хөрөнгө оруулалтын оновчлолын аргад суурилан сургууль, цэцэрлэг шинээр барих, өргөтгөх хэрэгцээг тооцож, үүнд суурилсан бодлого, төлөвлөлтийг тодорхойлов. Энэ хүрээнд | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | салбарын хэмжээнд хэрэгжүүлэх нийт 620 төсөл, арга хэмжээний урьдчилсан судалгаа гаргаж, тооцоо, судалгаа, шинжилгээ хийж гүйцэтгэн, 2025 оноос эхлэн хэрэгжүүлэхээр төсвийн хязгаарт тусгасан. Салбарын урт болон дунд хугацааны хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг дараах зарчим, бодлогод тулгуурласан. Үүнд: Бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан боловсролын сургалтын байгууллагын хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг хийх; Газарзүйн | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | мэдээллийн системийн хөрөнгө оруулалтын оновчлолын аргад суурилан сургууль, цэцэрлэг барих хэрэгцээг хамран сургах тойрог, хүчин чадал ашиглалтын хувь, хүн амын өсөлтийн тооцоололд үндэслэн гаргах; Их, дээд сургууль, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, дунд хугацааны таамаглалд үндэслэн хөгжүүлэх, түүнд шаардлагатай хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг хийх; Он дамжин хэрэгжиж | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байгаа, удаашралтай төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлж, бүрэн дуусгах; Шинээр ашиглалтад орох сургууль, цэцэрлэг, дотуур байрны тооцоонд үндэслэн хэрэгцээтэй тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээний төлөвлөлтийг хийх замаар Төсвийн хөрөнгө оруулалтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, хөрөнгийн ашиглалт, үр өгөөжийг нэмэгдүүлэх; Боловсролын багц хуулийн хэрэгжилтийг хангах, “Алсын Хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | туссан хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлэх, хүүхэд бүрийг эрүүл аюулгүй орчин сурч, хөгжих боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтыг төлөвлөлтийг хийх зэрэг болно. | | |
| 3.8.8 | 2012 оноос хойш хэрэгжиж байгаа, хугацаа хэтэрсэн, санхүүжилтийн эх үүсвэргүй болон бусад шалтгаанаар хэрэгжилт удаашралтай байгаа хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний судалгааг гаргаж, төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж дуусгах талаар авч хэрэгжүүлэх | Үйл ажиллагаан ы зардлаар | Бүрэн хэрэгжүүлж дуусгасан байх төсөл, арга хэмжээний тоо | 43 | Хэрэгжилт удаашралтай төсөл, арга хэмжээний судалгааг, тайлбар, мэдээллийн хамт бэлтгэсэн байна | 46 | Боловсрол, шинжлэх ухааны салбарт 2012 оноос үргэлжлэн хэрэгжиж байгаа 468 төсөл, арга хэмжээ буюу 419 барилга байгууламжаас Монгол Улсын 2023 оны төсөвт 1,805.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөг, 529.3 тэрбум төгрөгийн санхүүжих дүн бүхий 399 төсөл, арга хэмжээ буюу 1,537.44 | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | арга хэмжээний санал боловсруулах, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | | | | | | тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 130 цэцэрлэг, 16 цэцэрлэг, бага сургуулийн цогцолбор, 127 сургууль, 44 сургуулийн дотуур байр, 21 сургуулийн спорт заал, 3 МСҮТ, 4 их дээд, 1 шинжлэх ухааны нийт 361 барилга байгууламж байна. Он дамжин үргэлжлэн хэрэгжих 326 төсөл, арга хэмжээнээс 299 нь барилга байгууламж бөгөөд нэмэлт санхүүжилт шаардлагатай, батлагдсан төсөвт өртөгтөө багтан, гэрээний хугацаанд ашиглалтад орох боломжгүй 177 төсөл, арга хэмжээний 121 төсөл, арга хэмжээ нь нэмэлт ажлын | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | төсөв нь магадлалын нэгдсэн дүгнэлтээр баталгаажсан буюу 58 төсөл, арга хэмжээний гэрээг дүгнэн, үлдэгдэл ажлын тоо хэмжээний төсвийг тооцож, магадлал хийлгэхээр Барилгын хөгжлийн төвд 2023 оны 6-р сард хүргүүлсэн. | | |
| 3.8.9 | Боловсрол, шинжлэх ухааны салбарт шилжин хэрэгжих төсөл, арга хэмжээний барилга угсралтын ажлын явц, санхүүжилтийн судалгааг нягтлан гаргаж, барилга угсралтын ажил болон санхүүжилтийн гүйцэтгэлтэй нь уялдуулан Үндэсний аудитын зөвлөмж, дүгнэлтийг | Үйл ажиллагаан ы зардлаар | 2025 оны төсвийн төсөлд тусгаж, хүргүүлсэн байх төсөл, арга хэмжээний тоо | 601 төсөл, арга хэмжээний санал дээр судалгаа, шинжилгээ хийж ажилласан. | Харьяа байгууллагуудa ас төсвийн санал хүлээн авч, нэгтгэсэн байна. | 497 - 2025 оны төсвийн саналыг нэгтгэж хүргүүлсэн байна. | Салбарын дунд болон урт хугацааны хөрөнгө оруулалтын бодлогыг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалттай уялдуулан боловсролын сургалтын байгууллагын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, газар зүйн мэдээллийн системийн хөрөнгө оруулалтын | 100% | 100 % |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | үндэслэн Монгол Улсын 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн хязгаар, төсвийн төсөл, 2026-2027 оны төсвийн төсөөлөл боловсруулж, Сангийн яаманд хуулийн хугацаанд хүргүүлнэ. | | | | | | оновчлолын аргад суурилан сургууль, цэцэрлэг шинээр барих, өргөтгөх хэрэгцээг тооцож, үүнд суурилсан бодлого, төлөвлөлтийг тодорхойлов. Энэ хүрээнд салбарын хэмжээнд хэрэгжүүлэх нийт 618 төсөл, арга хэмжээний урьдчилсан судалгаа гаргаж, тооцоо, судалгаа, шинжилгээ хийж гүйцэтгэн, 2025 оноос эхлэн хэрэгжүүлэхээр төсвийн хязгаарт тусгасан. Салбарын урт болон дунд хугацааны хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг дараах зарчим, бодлогод тулгуурласан. Үүнд: Бүсчилсэн хөгжлийн | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | бодлоготой уялдуулан боловсролын сургалтын байгууллагын хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг хийх; Газарзүйн мэдээллийн системийн хөрөнгө оруулалтын оновчлолын аргад суурилан сургууль, цэцэрлэг барих хэрэгцээг хамран сургах тойрог, хүчин чадал ашиглалтын хувь, хүн амын өсөлтийн тооцоолold үндэслэн гаргах; Их, дээд сургууль, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | нийлүүлэлт, дунд хугацааны таамаглалд үндэслэн хөгжүүлэх, түүнд шаардлагатай хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг хийх; Он дамжин хэрэгжиж байгаа, удаашралтай төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлж, бүрэн дуусгах; Шинээр ашиглалтад орох сургууль, цэцэрлэг, дотуур байрны тооцоонд үндэслэн хэрэгцээтэй тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээний төлөвлөлтийг хийх замаар Төсвийн хөрөнгө оруулалтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, хөрөнгийн ашиглалт, үр | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | өгөөжийг нэмэгдүүлэх; Боловсролын багц хуулийн хэрэгжилтийг хангах, “Алсын Хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт туссан хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлэх, хүүхэд бүрийг эрүүл аюулгүй орчин сурч, хөгжих боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтыг төлөвлөлтийг хийх зэрэг болно. | | |
| 3.8.11 | Боловсрол, шинжлэх ухааны салбарт төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх замаар хөрөнгө оруулалтыг | Үйл ажиллагааны зардлаар | Боловсрол, шинжлэх ухааны салбарт төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх | 27 | 16 | 16 | Боловсрол, шинжлэх ухааны салбарт төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх замаар хөрөнгө | 70% | 70% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | нэмэгдүүлэх боломж бүрдүүлнэ. | | чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний тоо | | | | оруулалтыг нэмэгдүүлэх боломж бүрдүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын "2024 онд салбарын яам, агентлагийн эрхлэх асуудлын хүрээнд зарим чиг үүргийг хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх төлөвлөгөө"-нд тусгуулан батлуулсан. Төлөвлөгөөний дагуу боловсролын салбарт хувийн хэвшлээр гүйцэтгүүлж болох төрийн үйлчилгээг тодорхойлон ажиллаж байна. Мөн хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сурагчдын цахим технологи ашиглан хичээллэх, мэдээллийн технологийн ур чадварыг нэмэгдүүлэхэд чиглүүлэн оролцуулахаар Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй мэдээлэл технологийн компанийн төлөөллүүдтэй уулзалт зохион байгуулж, хүүхэд бүрт компьютер эсвэл таблетаар хангах төсөл, арга хэмжээнд хамтран ажиллах тухай санал боловсруулан, удирдлагуудад танилцуулсан. Саналын дагуу хүүхэд бүрт таблет төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр бэлтгэл хангаж байна. | | |
| 3.8.12 | Боловсрол, шинжлэх ухааны | Үйл ажиллагаан | Бүртгэл, мэдээллийн | - | 50 хувь | 100 хувь | Боловсрол, шинжлэх ухааны | 100% | 70% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | салбарын хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийн судалгаа, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан бий болгож, хяналтын ажлыг зохион байгуулах, хөрөнгийн бүртгэлийг нэгдсэн бүртгэл, мэдээллийн кодтой болгоно. | ы зардлаар | нэгдсэн сан бий болгох үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | | | | салбарын хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийн судалгаа, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан бий болгох ажлыг зохион байгуулахаар бэлтгэл ажил хангаж, https://esis.edu.mn/ программд өөрчлөлт, өргөтгөл хийлгэж байна. МБТБ-ын Бүртгэл мэдээллийн TVETS системийн сайжруулалтыг хийхээр БМТТөвтэй хамтран ажиллаж, салбарын хэмжээний бүртгэл, мэдээллийн сан байгуулах ажлын бэлтгэл ажлыг хангав. | | |
| 3.8.13 | Боловсрол, шинжлэх ухааны салбарын сар, | Үйл ажиллагааны зардлаар | Тайлан, мэдээг цахим технологи | - | 2 | 4 | Боловсрол, шинжлэх ухааны салбарын сар, | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | улирал, жилийн эцсийн төсөв, хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн мэдээ, тайланг түргэн шуурхай, үнэн зөв тайлагнах мэдээ, тайланг боловсронгуй болгож, дүн шинжилгээ хийх боломжийг бүрдүүлнэ. | | ашиглан боловсронгуй болгож, тайлагнасан байх хугацаа, давтамж | | | | улирал, жилийн эцсийн төсөв, хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн мэдээ, тайланг холбогдох журмын дагуу сар бүр гарган, сар болгоны 5-ны өдрийн дотор Сангийн яаманд хүргүүлж, тайлагнаж байна. 2023 оны төсвийн тухай хуулиар хэрэгжсэн 399 төсөл, арга хэмжээний жилийн эцсийн тайланг нэгтгэн боловсруулж , Сангийн яамтай тооцоо нийлж, төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгүүлэв. 2024 оны төсвийн жилд нийт 491 төсөл арга хэмжээ хэрэгжиж байга бөгөөд үүний 442 ТАХ 2024 | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | оны төсвийн тухай хуулиар санхүүжилт баталгаажсан, 55 төсөл, арга хэмжээ дуусаагүй үргэлжилж байна. Хэрэгжиж байгаа ТАХ ний дундаж гүйцэтгэл 66 хувьтай байна. Шинэээр 2024 онд 173 төсөл, арга хэмжээ хэрэгжихээр батлагдсан бөгөөд үүний 140 ТАХ нь барилга байгууламж болно. ХАА ны явц тендер зарлалт 50 хувьтай, ний 58 ТАХ тендер зарласан, 60 ТАХ ний зураг төсөв хийгдэж байна. Эдгээр хэрэгжүүлсэн ажлын мэдээллийг Meds.gov.mn, Igovernment.mn цахим хуудсуудад тогтмол | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тайлагнаж байна. | | |
